



МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /О.Амгаланбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Э.БАТБАЯР

011000169

**ШҮҮХИЙГ БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, БАЙРШЛЫГ  
ТОГТООХОД ХАРГАЛЗАН ҮЗЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

1. Шалгуур үзүүлэлтийн зорилго нь Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх чанарын болон тоон мэдээллийг оновчтой, бодитой, судалгаа, шинжилгээнд үндэслэн тодорхойлоход оршино.

2. Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад дараах зарчмыг баримтална:

- 2.1. Үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн байх;
- 2.2. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байх;
- 2.3. Шүүхийн хөгжлийн бодлого, "Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө"-тэй тус тус уялдсан байх;
- 2.4. Шүүхэд хандах иргэний үндсэн эрх, эрх чөлөөний баталгааг дордуулаагүй байх;
- 2.5. Шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байх;
- 2.6. Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулаагүй байх;
- 2.7. Шүүхийн ачааллыг харгалзсан байх;
- 2.8. Шүүгчийн орон тоо нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байх;
- 2.9. Эдийн засгийн хувьд үр ашигтай байх;
- 2.10. Олон улсын эрх зүйн хөгжлийн жишиг, чиг хандлага, сайн туршлагыг өөрийн орны онцлогт харьцуулан судалж, нийцүүлэн нутагшуулсан байх;
- 2.11. Шүүгчийн мэргэшсэн, шүүхийн дагнасан байдалд тулгуурлан шүүн таслах ажиллагааны чанарыг сайжруулах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн байх;
- 2.12. Шүүхийн дагнасан байдлыг хөгжүүлэхэд дагнасан шүүн таслах ажиллагааны үр нөлөө, шүүхийн зардлыг харилцан уялдаатай авч үзэх.

3. Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад анхан болон давж заалдах шатны шүүхийн саналыг авна.

4. Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад дараах үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтэд үндэслэнэ. Үүнд:

А.Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо – 11

Б.Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо – 4

В.Шүүхэд хандах иргэний эрхийн баталгаа, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх – 9

Хоёр. Дэд шалгуур үзүүлэлт – 10

А.Шүүхийн хүний нөөц – 6

Б.Төсөв, дэд бүтэц, техник хэрэгсэл – 4

5. Үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтэд хамаарах чанарын болон тоон мэдээлэл:

| №   | Шалгуур үзүүлэлт |   | Шалгуур үзүүлэлтийн тайлбар   | Мэдээллийн эх үүсвэр | Мэдээлэл цуглуулах арга зүй | Мэдээллийн хамрах хугацаа        |
|---|------------------|---|---|----------------------|-----------------------------|----------------------------------|
|   | 1                | 2   | 3   | 4                    | 5                           |                                  |
| <b>Нэг. Үндсэн шалгуур үзүүлэлт</b>               |                  |   |   |                      |                             |                                  |
| <b>А. Шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоо</b> |                  |   |   |                      |                             |                                  |
| 1   | 1                | Шүүн таслах ажиллагааны тайлан (Эрүү, иргэн, захиргаа)                          | Улирал, хагас, бүтэн жил  | ШЕЗ, ШТГ             | Статистик мэдээ             | 10 жил түүнээс дээш <sup>1</sup> |
| 2   | 2                | Хэргийн хөдөлгөөний мэдээлэл  | Хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөн | ШЕЗ, ШТГ             | Мэдээ, тайлан               | Сонгосон хугацаагаар             |
| 3   | 3                | Шүүхийн ачаалал   | Хэргийн болон ажиллагааны   | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 5 жил, түүнээс дээш              |
| 4   | 4                | Шүүгч дангаар болон бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэсэн хэрэг                     | Хэрэг, зөрчил   | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 5 жил, түүнээс дээш              |
| 5   | 5                | Нийт шүүх хуралдаан (Хэлэлцүүлэг хамаарахгүй)                                   | Шүүгч дангаар болон бүрэлдэхүүнтэй явуулсан хуралдаан байх  | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 5 жил, түүнээс дээш              |
| 6   | 6                | Шүүх бүрэлдэхүүнд оролцохоор шүүгч томилолтоор ажилласан байдал, зардлын хэмжээ | Урт, богино хугацааг хамруулна  | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 5 жил, түүнээс дээш              |
| 7   | 7                | Шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогчийн тоо                                | Биечлэн оролцсон, биечлэн оролцоогүй  | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 3 жилээс дээш                    |
| 8   | 8                | Давж заалдах шатны шүүхээр хянагдсан анхан шатны шүүхийн шийдвэрийн тоо, чанар  | Хүчингүй, өөрчлөлт, хэвээр  | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 3 жилээс дээш                    |
| 9   | 9                | Хяналтын шатны шүүхээр хянагдсан анхан, давж заалдах                            | Хүчингүй, өөрчлөлт, хэвээр  | ШЕЗ, ШТГ             | Тоо, хувь                   | 3 жилээс дээш                    |

<sup>1</sup> Урт хугацааны үр дагавар, хэрэгцээг тодорхойлох

|   |    |  |  |                 |                                    |                      |
|---|----|--|--|-----------------|------------------------------------|----------------------|
|   |    | шатны шүүхийн шийдвэрийн тоо, чанар  |  |                 |                                    |                      |
| 10  | 10 | Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нутаг дэвсгэрт байрлах хорих ангийн нэршил, хоригдлын тоо, тухайн хорих ангид хийсэн хуралдааны тоо, хувь, зардлын хэмжээ | Шүүгч биечлэн очсон болон цахимаар явагдсан  | ШТГ             | Тоо, хувь                          | 3 жилээс дээш        |
| 11  | 11 | Шүүн таслах ажиллагааны тодорхой төрлөөр шийдвэрлэсэн хэргийн тоо  | Дагнасан шүүх байгуулах талаар   | ШТГ, ШССМХ, ШЕЗ | Статистик мэдээ, судалгааны тайлан | 5 жилээс дээш        |
| <b>Б. Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо</b>   |    |  |  |                 |                                    |                      |
| 12  | 1  | Нутаг дэвсгэрийн хэмжээ  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэршил, талбайн хэмжээ м2                                      | БХБЯ, МУУСХ     | Статистик                          | Сүүлийн байдлаар     |
| 13  | 2  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хүн ам  | Бүртгэлтэй, бүртгэлгүй, дамжин өнгөрдөг  | НХХЯ, ҮСХ       | Статистик                          | 3 жилээс дээш        |
| 14  | 3  | Хүн амын нягтрал   | Улсын дундаж болон аймаг, хот, сум, дүүрэг, баг, хороо   | ҮСХ             | Статистик                          | 3 жилээс дээш        |
| 15  | 4  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хуулийн этгээд  | Бүртгэлтэй хуулийн этгээдийн төрөл, тоо  | ҮСХ             | Статистик                          | Сонгосон хугацаагаар |
| <b>В. Шүүхэд хандах иргэний эрхийн баталгаа, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэх</b> |    |  |  |                 |                                    |                      |
| 16  | 1  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил залгаа засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төв хоорондын зай   | Алслагдмал байдлын тодорхойлох км2   | БХБЯ, ЗТХЯ      | Судалгаа                           | Сүүлийн байдлаар     |
| 17  | 2  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил залгаа улс, хилийн боомт   | Хэргийн төрөл, хүн амын хөдөлгөөний ачааллыг тооцох  | ЗДТГ            | Статистик, тайлан                  | -                    |
| 18  | 3  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх нэг хүнд ногдох бүртгэгдсэн хэрэг, хэргийн гаралт, төрөл  | Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг  | ШЕЗ, ЦЕГ, МУУСХ | Статистик, тайлан                  | 3 жил, түүнээс дээш  |
| 19  | 4  | Зам  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төв хоорондын улсын болон орон нутгийн чанартай авто зам | ЗТХЯ            | Батлагдсан замын сүлжээ зураг      | Сүүлийн байдлаар     |
| 20  | 5  | Нийтийн тээвэр   | Хотын болон хот хоорондын авто, төмөр, агаарын тээврийн чиглэл, хуваарь, төлбөр                  | ЗТХЯ, АТҮТ      | Судалгаа                           | Сүүлийн байдлаар     |
| 21  | 6  | Мэдээллийн технологийн дэд бүтэц, харилцаа холбоо  | Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр төрийн өмчит шилэн                                     | ХХМТГ           | Судалгаа                           | Сүүлийн байдлаар     |

|   |   |  |   |  |  |                      |
|---|---|--|---|--|--|----------------------|
|   |   |  | кабелийн сүлжээ, хөдөлгөөнт болон суурин интернэт хэрэглэгч   |  |  |                      |
| 22  | 7 | Эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн үзүүлэлт   | Тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, дэд бүтэц, хүн ам, нийгмийн байдлын хөгжлийн дэлгэрэнгүй үзүүлэлт | МУҮСХ, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв | Өрсөлдөх чадварын тайлан болон улс, хот, аймаг, дүүргийн нийгэм эдийн засгийн байдал статистик эмхтгэл | 3 жил, түүнээс дээш  |
| 23  | 8 | Бүс, аймаг, хот, тосгон, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө   | Засаг, захиргааны нэгжийн тэлэлт, дагуул хот, тосгон, үйлдвэр, уурхайг дагах хүн амын суурьшлыг харгалзан тооцох                | БХБЯ   | Батлагдсан төлөвлөгөө  | Сүүлийн байдлаар     |
| 24  | 9 | Хүн амд ногдох шүүгчийн тоон үзүүлэлтийг нийт улсын хэмжээнд, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд тооцоолсон судалгаа | Харьцуулан гаргах   | ШТГ, ШЕЗ   | Статистик мэдээ, судалгааны тайлан   | 3 жилээс дээш        |
| <b>Хоёр. Дэд шалгуур үзүүлэлт</b>           |   |  |   |  |  |                      |
| <b>А. Шүүхийн хүний нөөц</b>                |   |  |   |  |  |                      |
| 25  | 1 | Шүүгчийн орон тоо  | Батлагдсан, ажиллаж байгаа, нэмэгдүүлэх   | УИХ-ын тогтоол, ШЕЗ  | Судалгаа   | 5 жил, түүнээс дээш  |
| 26  | 2 | Шүүгчийн ажлын ачаалал   | Нийслэл, аймаг, сум дундаарх хэргийн болон ажиллагааны  | ШЕЗ  | Судалгаа   | 5 жил, түүнээс дээш  |
| 27  | 3 | Шүүхийн захиргааны ажилтны орон тоо  | Батлагдсан, ажиллаж байгаа, нэмэгдүүлэх орон тоо болон олдцыг тооцно  | ШЕЗ  | Судалгаа   | 3 жил, түүнээс дээш  |
| 28  | 4 | Шүүхийн захиргааны ажилтны ажлын ачаалал   | Албан тушаал бүрээр нийслэл, аймаг, сум дунд  | ШЕЗ  | Судалгаа   | 3 жил, түүнээс дээш  |
| 29  | 5 | Шүүгчийг сэлгэн ажиллуулсан талаарх судалгаа   | Тоон болон чанарын судалгаа   | ШТГ, ШЕЗ   | Статистик мэдээ, судалгааны тайлан   | 3 жилээс дээш        |
| 30  | 6 | Шүүхийн захиргааны ажилтны нөөцийн талаарх судалгаа  | Тоон болон чанарын судалгаа   | ШТГ, ШЕЗ   | Статистик мэдээ, судалгааны тайлан   | Сонгосон хугацаагаар |
| <b>Б. Төсөв, дэд бүтэц, техник хэрэгсэл</b> |   |  |   |  |  |                      |
| 31  | 1 | Шүүхийн төсөв  | Хүргүүлсэн, өргөн мэдүүлэгдсэн, батлагдсан  | УИХ, СЯ, ШЕЗ   | Тайлан, мэдээ  | 10 жилээс дээш       |

|    |   |  |   |          |                                    |                |
|----|---|--|---|----------|------------------------------------|----------------|
| 32 | 2 | Шүүхийн үндсэн хөрөнгө   | Байр (шүүх хуралдааны танхим), тавилга, техник, тоног төхөөрөмж | ШЕЗ      | Судалгаа                           | 10 жилээс дээш |
| 33 | 3 | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал                                  | 1 хэрэгт ногдох дундаж урсгал зардлын хэмжээ                    | ШЕЗ, ШТГ | Судалгаа                           | 3 жилээс дээш  |
| 34 | 4 | Шүүгчийн цалингийн сангийн талаарх улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ | Тоон болон чанарын судалгаа                                     | ШТГ, ШЕЗ | Статистик мэдээ, судалгааны тайлан | 5 жилээс дээш  |

**Товчилсон үгийн жагсаалт:**

|       |  |
|-------|--|
| УИХ   | Улсын Их Хурал                                 |
| СЯ    | Сангийн яам                                    |
| БХБЯ  | Барилга, хот байгуулалтын яам                  |
| ЗТХЯ  | Зам, тээврийн хөгжлийн яам                     |
| ХНХЯ  | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам              |
| ХХМТГ | Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар |
| МУСҮХ | Монгол Улсын статистикийн үндэсний хороо       |
| АТҮТ  | Авто, тээврийн үндэсний төв                    |
| ЦЕГ   | Цагдаагийн ерөнхий газар                       |
| ШЕЗ   | Шүүхийн ерөнхий зөвлөл                         |
| ШТГ   | Шүүхийн тамгын газар                           |

--oOo--